

Монгол Улс дахь Герман хэлний сургалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага

Д.Лхамхүү,

С.Отгонжаргал, С.Амаржаргал

Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Нийгэм

хүмүүнлэгийн ухааны сургууль

Англи, Герман хэлний тэнхим,

Хураангуй

Герман хэлний сургалт эдүгээ 28 жилийн хугацаанд Монгол Улсын гадаад хэлний бодлого, зах зээлийн эрэлт хэрэгцээ, хувь хүний хүсэл сонирхолтой холбоотойгоор өөрчлөлт хувьслын давалгаан дунд хөгжсөөр иржээ. Энэхүү илтгэлээр Монгол Улс дахь Герман хэлний сургалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодруулахдаа дараах асуудлуудыг хөндөхийг хичээлээ. Үүнд:

- ЕБС, МСҮТ-үүд дэх герман хэлний сургалтын өнөөгийн байдал, гадаад харилцаа болон хамтын ажиллагаа
- Их дээд сургуулиуд дахь герман хэлний сургалтын өнөөгийн байдал, гадаад харилцаа болон хамтын ажиллагаа
- Хэлний сургалтын төвүүд дэх герман хэлний сургалтын өнөөгийн байдал
- Монгол Улс дахь Герман хэлний сургалтын цаашдын чиг хандлага

Дээрх асуултад хариулт авахын тулд эх сурвалжуудтай ажиллахын зэрэгцээ байгууллага, хувь хүмүүстэй уулзан ярилцлага хийн мэдээ, тоон баримтуудыг цуглуулсан болно. Герман хэл зөвхөн Улаанбаатар хотоор хязгаарлагдахгүй хөдөө орон нутгийн ЕБС-иудын гадаад хэлний сургалтын хөтөлбөрт орсон нь хүүхэд залуучууд герман хэл сурах хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буйг харуулж байна. Тэгэхээр Герман хэлний сургалттай ЕБС-иудын тоо болон гадаад хэлний курс дамжаануудад герман хэл суралцагчдын тоо өсөхийн хэрээр герман хэлний багшийн ажлын байр нэмэгдэж байна. Тиймээс "Герман хэлний багш" бэлтгэх бакалаврын сургалтыг цаашид чанарын өндөр түвшинд зохион байгуулах шаардлагатай байна. Түүнчлэн зах зээлийн, нээлттэй эдийн засгийн өнөөгийн нийгэмд гадаад харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийг хувь хүн, байгууллага бүр хичээж байна. Тийм учир гадаад хэл харилцааны хэрэглүүр төдийгүй ажил мэргэжлийн салшгүй нэгэн хэсэг болжээ. Иймээс боловсролын бүх шатанд мэргэжилд суурилсан герман хэлний сургалтыг зохион байгуулах шаардлага байна.

Түлхүүр үг

Герман хэлний сургалт, герман хэлний багш, мэргэжилд суурилсан герман хэлний сургалт

Удиртгал

Герман хэлний боловсролын түүхэн хөгжил

Монгол - Германы боловсролын салбар дахь хамтын ажиллагаа үүсэж хөгжөөд эдүгээ 93 жил болжээ. Бараг нэгэн зууны тэртээ буюу 1926 онд дунд сургуулийн боловсролтой 40 шахам хүүхэд залуус "Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас" эрдэм өвөртлөн ирэхээр харь гүрнийг зорьсон билээ. Эдгээр залуус хожмоо Монгол Улсын шинжлэх ухаан, боловсрол, соёл урлаг, төр нийгэм, улс ардын аж ахуйн тэргүүлэх сэхээтнүүд болж, алдар нэрээ мөнхөлсөн түүхтэй.

1950 онд Ардчилсан Герман Улстай дипломат харилцаа тогтоосноор Монгол улсын хөгжил, боловсролд ихээхэн дэмжлэг туслалцаа үзүүлж эхэлсэн билээ. Энэхүү хамтын

ажиллагааны хүрээнд олон мянган монгол залуус Герман улсад тэтгэлэгтэйгээр суралцан, тэдний үлгэр дуурайллаар үр хүүхэд, ач гуч, найз нөхөд нь Герман улстай амьдрал, ажил хөдөлмөрөө холбосон тэрхүү жим өдий хүртэл тасрахгүй явна.

Монгол Улсад герман хэлний сургалтыг анх 1968 онд МУИС-ийн Хэл Бичгийн факультетийн Гадаад хэлний тэнхимийн үйл ажиллагааны хүрээнд Лайпцигийн Их Сургуулийн Хердер Институтын багш Карл Крюгер, Лайпцигийн Их Сургуулийг Герман судлаач мэргэжлээр дүүргэсэн Чинагийн Галсан нар физик, математикийн анги, монгол хэлний ангийн зарим нэгэн оюутан, МУИС-ийн багш

✉ lkhamkhuu.d@msue.edu.mn

нарын дугуйланд хичээл заан эхлүүлсэн байна (Ариун, Одонтуяа, 2009, 202-211). Монгол-Германы хамтын ажиллагаа гүнзгийрэхийн хэрээр Монгол улс дахь герман хэлний сургалт өргөжин тэлж байлаа. 1975-1990 оны хооронд Германы их дээд сургууль, тусгай мэргэжлийн сургуульд суралцах оюутан сурагчдын тоо нэмэгдэж, МУИС-ийн Гадаад хэлний тэнхим нь Германы Инженерийн бэлтгэл ангийн оюутнуудад нэг жилийн хэлний сургалт явуулж эхэлснээр Монгол Улс дахь өнөөгийн герман хэлний мэргэжлийн сургалтын суурь тавигдсан юм.

Ардчиллын үр нөлөөгөөр Монгол улс олон хэлний бодлогыг дэмжиж 1991 онд улсын болон хувийн их дээд сургуулиудад герман хэлний багш-орчуулагч, хэл судлаач, хэл-орон судлаач, герман хэлээр мэргэжсэн гадаад албаны ажилтан бэлтгэх суурь тавигдсан билээ. Герман хэлний сургалт эдүгээ 28 жил нутагших хугацаандаа Монгол Улсын хэлний бодлого, зах зээлийн эрэлт хэрэгцээ, хувь хүний хүсэл сонирхолтой холбоотойгоор өөрчлөлт хувьслын давалгаанд хөгжсөөр иржээ.

Энэхүү өгүүлэлдээ Монгол Улс дахь Герман хэлний сургалтын өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагыг тодруулахыг зорьсон бөгөөд дараах асуудлуудыг хөндөхийг хичээлээ. Үүнд:

- ЕБС, Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн системийн сургуулиудын герман хэлний сургалтын өнөөгийн байдал, гадаад харилцаа болон хамтын ажиллагаа
- Их дээд сургуулиудын герман хэлний сургалтын өнөөгийн байдал, гадаад харилцаа болон хамтын ажиллагаа
- Хэлний сургалтын төвүүдийн герман хэлний сургалтын өнөөгийн байдал
- Монгол улсын Герман хэлний сургалтын цаашдын чиг хандлага

1. Герман хэлний сургалтын өнөөгийн байдал

1.1. ЕБС, Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн систем дахь герман хэлний сургалтын өнөөгийн байдал, гадаад харилцаа болон хамтын ажиллагаа

1990 оноос эхлэн ЕБС-ийн зарим сургуульд герман хэлийг хоёр дахь гадаад хэл болгон сонгон үзэж эхэлсэн билээ. 1998 онд ХБНГУ-ын ерөнхийлөгч Роман Херцог Монголд айлчлан Монгол – Германы хамтарсан сургууль байгуулах тухай мэдэгдэл хийснээр 1999 онд 38-р дунд сургуулийг Монгол – Германы хамтарсан сургууль болгосноор монголын хүүхэд багачууд Ерөнхий Боловсролын сургалтын хүрээнд нэгдүгээр ангиасаа эхлэн герман хэлийг сурах боломж бүрдсэн юм. Нийт 185 сая орчим хүн

ярьдаг герман хэл нь дэлхийн хэлнүүдийн аравт эрэмбэлэгддэг ч гэсэн дэлхий даяараа англи хэлийг чухалчлан судалж байна. Хэдий Монгол Улсад англи хэл нь албан ёсны нэгдүгээр гадаад хэл боловч герман хэлийг ЕБС-д хоёр дахь гадаад хэл болгон судлах боломж нэмэгдэж, суралцагчдын тоо жил ирэх тусам өсөж байна. 2009 оны байдлаар 6 ЕБС герман хэлний сургалт явуулж байсан бол 2011 онд 9 ЕБС-д ойролцоогоор 1800 сурагч герман хэл сурч байжээ (Naranchimeg, 2011, 1744-1746). Харин 2019 оны байдлаар 14 ЕБС-д ойролцоогоор 3088 сурагч герман хэл сурч байна. (Хавсралт 1)

Дээр дурдсан тоо баримтаас харахад герман хэл заадаг сургалтын байгууллагууд нэмэгдэхийн зэрэгцээ герман хэл сонирхон суралцагчдын тоо мэдэгдэхүйц өссөн байна.

Үүнд нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үзвэл:

- ХБНГУ-ын хилийн чанад дахь Ерөнхий Боловсролын Асуудал Эрхэлсэн Төв (ZfA) болон Гёте Институтээс хэрэгжүүлдэг төсөл хөтөлбөрүүд, ялангуяа „Ерөнхий боловсролын сургууль: Ирээдүйн түнш” (PASCH) хөтөлбөр герман хэлийг сонирхон сурагчдын тоог өсөн нэмэгдэхэд гол түлхэц үзүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн хүрээнд багш боловсон хүчний мэргэжил дээшлүүлэх, сургалтын орчин, материаллаг баазыг сайжруулах тал дээр дэмжлэг туслалцаа үзүүлэн, ЕБ-ын сургуулиудтай байнгын эргэх холбоотой хамтран ажиллаж байна.
- Үүний зэрэгцээ сурагчдад Германы Их дээд сургуулиудад элсэн орох хэлний мэдлэгийн баталгаат шалгалт өгөх боломж нээгдсэн нь дунд сургуулийн герман хэлний сургалтын чанарыг сайжруулахад болон герман хэл сонгон суралцагчдын тоо нэмэгдэхэд ихээхэн нөлөөлж байна.
- Мөн зах зээлийн нээлттэй эдийн засгийн нөлөөгөөр гадаад харилцаа тэлэхийн хэрээр хүн бүр гадаад хэлний хэрэгцээ шаардлага, ач холбогдлыг ойлгон олон хэл эзэмшихийг зорьж байна. Ихэнхдээ эцэг эхчүүд хүүхдүүддээ гадаад хэлээ сонгоход нь тусалдаг. Тэд ихэнхдээ герман хэл сурах нь ирээдүйд ажил мэргэжлийн хувьд өсөн дэвжих боломжуудыг нээж өгнө гэсэн бодлоор сонголтоо хийдэг гэжээ.
- Герман хэл сонирхон сурах бас нэгэн гол хөшүүрэг нь нэг талаас германы хүчирхэг эдийн засгийн нэр нөлөө, нөгөө талаас чанартай боловсролын тогтолцоо болно. Түүнчлэн Герман улсын талаар мэдлэгтэй болох сонирхол ч өссөөр байна. Герман

Улсад их дээд сургуулийн боловсролыг хүн бүр үнэгүй эзэмших боломжтой билээ. Иймээс ХБНГУ-ын боловсролын чанар болон сурах таатай нөхцөл нь хүүхдүүдэд Герман Улсад мэргэжил эзэмших хүсэл сонирхлыг ихээхэн төрүүлж байна.

Сүүлийн жилүүдэд мэргэжлийн сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд (МСҮТ) сургалтын чанартаа ахиц гаргах, технологийн дэвшил нэвтрүүлэх зорилгоор гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэхэд ихэд анхааран ажиллаж байна. Барилгын Политехникийн Коллеж нь Германы Олон Улсын Хамтын Ажиллагааны Нийгэмлэг болон ХБНГУ-ын хилийн чанад дахь Ерөнхий Боловсролын Асуудал Эрхэлсэн Төвтэй (ZfA) хамтран хэрэгжүүлж буй төслийн хүрээнд “Мэргэжил үйлдвэрлэлийн сургууль” дахь герман хэлний сургалтыг цоо шинээр явуулж, 2019 оны байдлаар 90 суралцагчийг мэргэжилд суурилсан герман хэлний сургалтад хамруулаад байна. Цаашид эдгээр суралцагчдад Герман улсад үргэлжлүүлэн суралцах, мэргэжил дээшлүүлэх боломж бүрдэж байгаа юм.

1.2. Их дээд сургуулиуд дахь герман хэлний сургалтын өнөөгийн байдал, гадаад харилцаа болон хамтын ажиллагаа

Харин Монгол Улсын дээд боловсролын салбар дахь герман хэлний сургалтын байдал арай өөр байна. 2006 оны байдлаар Монгол Улсад төрийн өмчийн 5 болон хувийн өмчийн 10 их дээд сургуульд “герман хэл судлаач”, “герман хэлний багш”, “герман хэлний орчуулагч” зэрэг чиглэлээр мэргэжилтэн бэлтгэн гаргаж байсан бол 2019 оны байдлаар төрийн өмчийн 5, Монгол-Германы хамтарсан 1 их дээд сургуульд мэргэжлийн болон мэргэжлийн бус герман хэлний сургалт зохион байгуулж байна. 2009 онд төрийн болон хувийн их, дээд сургуулиудад 517 оюутан мэргэжлийн герман хэлний сургалтад хамрагдаж байсан бол энэ тоо жил ирэх тусам буурч 2019 оны байдлаар 145 оюутан дээрх 3 мэргэжлээр суралцаж байна. Мэргэжлийн ангид суралцагчдын тоо буурсан үзүүлэлттэй байгаа хэдий ч 2009 онд ерөнхий герман хэлийг мэргэжлийн бус ангийн 321 оюутан сурч байсан бол 2019 оны байдлаар 586 оюутан судалж байна (Ариун, Одонтуяа, 2009, х.202-211). (Хавсралт 2)

Их дээд сургууль дахь герман хэлний сургалтад нөлөөлж буй эерэг болон сөрөг хүчин зүйлсийг дурдвал:

- Боловсролын шинэчлэлийн хүрээнд сургалтын чанарыг дээшлүүлэх зорилгоор төрийн бус сургуулиудын тоог цөөлөх, салбар нэгжүүдийг нэгтгэх арга хэмжээ авч

байна.

- Герман хэлний сургалттай ЕБС-ийн тоо нэмэгдэхийн хэрээр герман хэлний багшийн эрэлт хэрэгцээ жил ирэх тусам ихсэж байгаа ч нийгэмд багш мэргэжлийн нэр хүнд, цалин үнэлэмж доогуур байгаагаас шалтгаалан багш мэргэжлийг сонгон суралцах, цаашилбал тухайн мэргэжлээр ажиллах сонирхол бага байна.
- Дараагийн нэг шалтгаан нь ажлын байрны олдоц хангалттай биш тул “Герман судлал”, “герман хэлний орчуулагч” мэргэжлийн эрэлт хэрэгцээ буурахад хүргэж байна.
- Дээд боловсролын салбарт Германы Эрдмийн Солилцооны Алба /DAAD/-ны Монгол улс дахь суурин төлөөлөгчийн гурван газраараа дамжуулан төрөл бүрийн төсөлт хөтөлбөр хэрэгжүүлэн сургалт-судалгааг дэмжин ажиллаж байна. ГЭСА нь Их, Дээд Сургуулийн герман судлал, герман хэлний багш бэлтгэх сургалтыг дэмжин, герман хэлний багш нарыг эрдэм шинжилгээ судалгааны ажилд чадваржуулах тал дээр ихээхэн анхааран ажилладаг билээ. Төсөлт хөтөлбөрийн хүрээнд Герман Улсад магистр, докторантурт тэтгэлэгтэйгээр суралцах боломжтой байдаг нь бакалаврын ангийн оюутнуудад маш том хөшүүрэг болдог.
- Их, дээд сургуулиуд нийгмийн шаардлага, оюутан залуусын эрэлт хэрэгцээ, сонирхлыг харгалзан, олон хэлний бодлогыг дэмжиж байгаа билээ. 2016-2018 оны хичээлийн жилээс эхлэн сургалтын хөтөлбөрт мэргэжлийн бус ангийн оюутнуудад гадаад хэлийг санал болгосноор герман хэлийг сонгох судлах оюутны тоо өсөн нэмэгдэхэд нөлөөлж байна.
- Хэдий герман хэлний уламжлалт мэргэжлийн ангийн байдал ороо бусгаа байгаа ч их, дээд сургуулийн герман хэлний сургалт шинэ өнгө төрхөөр өргөжин тэлж байна. Үүний нэг тод жишээ нь мэргэжилд суурилсан герман хэлний сургалт юм.
- Монгол улс дэлхийн хэмжээнд түүхий эдийн нөөцөөр тэргүүлэх орны нэг. Гэвч түүхий эд боловсруулах үйлдвэр, түүний салбар нэгжүүдэд ажиллах чадварлаг боловсон хүчин, мэргэжилтэн, удирдах шатны албан хаагчид дутмаг байгаа нь нууц биш. Энэ эрэлт хэрэгцээг зохицуулахын тулд ХБНГУ, Монгол Улс хоорондын хамтын ажиллагааны хүрээнд тэтгэлэг олгох төсөлт ажлууд хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд 2013 онд Монгол-Германы хамтарсан Уул уурхай, Технологийн Дээд Сургууль (GMIT) -ийг

байгуулснаар герман хэл сурах суралцагчдын тоо нэмэгдэхэд ихээхэн нөлөөлж байна.

1.3. Хэлний сургалтын төвүүд дэх герман хэлний сургалтын өнөөгийн байдал

Герман улс хэзээнээс монголчуудын сурч, амьдрах хүсэлтэй орнуудын нэг байдаг тул герман хэл сурах хүсэл сонирхолтой залуусын тоо нэмэгдсээр байгаа. Эдүгээ 18 хэлний төв герман хэлний бүх түвшингээр урт богино хугацааны сургалт зохион байгуулж байна. (Хавсралт 3)

2001 онд Монгол Улс Европын хэлний нэгдсэн стандартын ахисан түвшний Test-DaF шалгалтыг зохион байгуулдаг албан ёсны төлөөлөгчтэй болсон. 2009 онд ХБНГУ-ын соёлын байгууллага болох Гёте-Институт нь Монгол Улсад өөрийн төлөөлөгчийн газраа нээснээр герман хэл сонирхогчид эх орондоо шалгалт өгөн, герман хэлний олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн гэрчилгээ авах боломж бүрдлээ. 2016 оны байдлаар Гёте-Институтын герман хэлний түвшин тогтоох шалгалтад 620 хүн хамрагдсан бол 2018 оны байдлаар 1441 болж өссөн байна. (Хавсралт 4) Герман хэлний курс болон шалгалтад хамрагдагсдын зорилго янз бүр. Хүүхэд залуусын ихэнх нь Германы их, дээд сургуулиудад суралцах, Герман Улсад хүүхэд асрагчаар явах хүсэлтэй байна. Сүүлийн жилүүдэд Монгол-Германы хамтын ажиллагаа өргөжиж байгаагийн илрэл олон салбарын (сувилагч, үйлдвэрийн ажилчид, ус хангамж г.м.) мэргэжилтнүүд, ажилчид Герман Улсад урт богино хугацаагаар ажиллаж, суралцах болсноор герман хэл сонирхон суралцагчдын тоо нэмэгдэхэд нөлөөлж байна.

2. Герман хэлний сургалтын цаашдын чиг хандлага

Монгол-Германы хамтын ажиллагаа нийгэм, боловсрол, эдийн засгийн бүх салбарт өргөжин тэлж байгаа энэ үед Монгол Улс дахь Герман хэл сурах, сургах болон судлах үйл ажиллагааг тасралтгүй хөгжүүлэх шаардлага бидэнд бий.

Монгол Улс дахь Герман хэлний сургалтын цаашдын чиг хандлагыг тоймлон харвал:

Герман хэл зөвхөн Улаанбаатар хотоор хязгаарлагдахгүй хөдөө орон нутгийн ЕБС-иудын гадаад хэлний сургалтын хөтөлбөрт орсон нь хүүхэд залуучууд герман хэл сурах хүсэл сонирхол, эрэлт хэрэгцээ өсөн нэмэгдэж буйг харуулж байна. Тэгэхээр Герман хэлний сургалттай ЕБС-иудын тоо болон гадаад хэлний курс дамжаануудад герман хэл суралцагчдын тоо өсөхийн хэрээр герман хэлний багшийн ажлын байр нэмэгдэж байна. Тиймээс “Герман хэлний

багш” бэлтгэх бакалаврын сургалтыг цаашид чанарын өндөр түвшинд зохион байгуулах шаардлагатай байна.

Зах зээлийн, нээлттэй эдийн засгийн өнөөгийн нийгэмд герман хэлтэй улс орнуудтай гадаад харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэхийг хувь хүн, байгууллага бүр хичээж байна. Тийм учир гадаад хэл, түүний дотор герман хэл бизнесийн харилцааны хэрэглүүр төдийгүй ажил мэргэжлийн салшгүй нэгэн хэсэг болжээ. Иймээс боловсролын бүхий шатанд мэргэжилд суурилсан герман хэлний сургалтыг зохион байгуулах шаардлага байна.

Түүнчлэн байгалийн шинжлэх ухаан, биотехнологи, нанотехнологи, уул уурхай, сэргээгдэх эрчим хүч, анагаах ухааны чиглэлээр Герман улсын дэлхий дахинд эзэлж буй тэргүүлэх байр суурийг харгалзан үзэж эрдэмтэн солилцоо, оюутан солилцооны хөтөлбөрүүдийг системтэйгээр идэвхжүүлж, энэ хөтөлбөрүүдээ амжилттай, үр дүнтэй байлгах үндсэн нөхцөл болсон герман хэлний боловсрол, сургалтын түргэвчилсэн шинэлэг системийг бүх шатанд цогцоор нь боловсруулж, төрийн бодлогоор дэмжин ажиллавал ойрын ирээдүйд ихээхэн үр өгөөжтэй байх боломж бий гэж үзэж байна.

Талархал

Энэхүү судалгааны өгүүллийг бичихэд герман хэлний сургалтын өнөөгийн нөхцөл байдлын талаарх мэдээ, тоо баримтаар туслалцаа үзүүлсэн бүх байгууллага, багш нарт чин сэтгэлийн талархал илэрхийлье.

Ном зүй

- Ариун. Ж, Одонтуяа. М. 2009: “Монгол Улс дахь Герман хэлний сургалтын өнөөгийн байдал”. МУИС, ГХСС, “Гадаад хэл соёл” ЭШБ №314(13), 202-211 тал
- Наранчимэг. Х. (2011): „Deutsch in der Mongolei“, *Deutsch als Fremd- und Zweitsprache. Ein internationales Buch 2. Halbband 1744-1746* тал
- Оюунгэрэл.Л. (2004): “Монгол дахь Герман судлалын үүсэл хөгжил”, “Монгол-Германы харилцаа. Өнгөрсөн үе- Эдүгээ – Хэтийн төлөв”, Улаанбаатар хот, 158-161 тал

https://mn.wikipedia.org/wiki/38-p_сургууль

Current development and further tendency of german language training in mongolia

Lkhamkhuu.D, Otgonjargal.S, Amarjargal.S, MNUE

Abstract

German teaching/learning has been gradually developing for last 28 years, through waves changes prompted by foreign language policy of the country, market demand and interest of individuals. Hence, we attempted to address on below aspects whilst identifying current state of German teaching/learning in Mongolia:

- Current state of German teaching/learning, foreign affair and collaboration at Secondary and High schools and Professional Training Centers.
- Current state of German teaching/learning, foreign affair and collaboration at Universities and Colleges
- Current state of German teaching/learning at foreign language learning centers

Prospective tendency of German teaching/learning in Mongolia In order to obtain answers to these research questions, we interviewed organizations and individuals; and collected result data as well as working other sources. Increased presence of German language in foreign language program of secondary schools that are not only in Ulaanbaatar but also in rural area, suggests growing interest and necessity among youth to learn German. This growing number of secondary schools with German program and German learners at language centers convey an increase of work position in German teaching. Therefore, it is critical to conduct high quality undergraduate programs that prepare German teachers. In this market-economy based society, individuals and entities are more driven toward developing foreign partnership and collaboration. Out of this nature, foreign language (German) plays in role of not only communication mean but also critical part in professional endorsement. The necessity of conducting professional subject focused German teaching/learning at all levels of educational system has been greatly recognized.

Keywords

German learning und teaching, teacher for german, professional german
